

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын оорчлолт, малын торлийн зохистой бус харьцаа, малын хэт боогнорол, бэлчээрийн зохисгүй ашиглалт зэргээс үүдэн бэлчээрийн бүтэц бүрэлдэхвн, тэжээлийн нооцод ихээхэн оорчлолт орсноор бэлчээрийн доройтол улам бүр эрчимжсээр байна.

Монголын нийт хvн амын гуравны нэг хувийн амьдралын эх үүсвэр болсон бэлчээр доройтон малчдын нийгэм эдийн засгийн байдал хvндэрч ядуурал нэмэгдэж буй оноо вед бэлчээрийн зохистой, тогтвортой менежментийн судалгаан дээр тулгуурласан, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого, стратеги юу юунаас илvv чухал байна.

Дэлхий дахинд оноог хvртэл хийгдэж ирсэн бэлчээрийн судалгаа, үнэлгээ мониторингийн ажлуудын дутууг нохох үүднээс боловсруулагдсан бэлчээрийн эрүүл мэндийн судалгааны үзэл баримтлал нь экосистемийн бүхий л үйлчилгээ, тvvний дотор бэлчээрийн бүтээмж нь хорсний элэгдэл, доройтлын тvвшин, ус шингээх, барих, нэвтрүүлэх чадвар, ургамлын бүлгэмдлийн тогтвортой бүтээмжээс шууд хамаардаг гэсэн таамаглал дээр суурилсан байдаг .

Бэлчээрийн тухайн жилийн бүтээмжээс шууд хараат Монголын МАА-н үйлдвэрлэлийн хувьд бэлчээрийн гарц бүтээмжийг урт хугацааны турш ондор тvвшинд байлгах гол үндэс бол бэлчээрийн эрүүл мэндийн асуудал болохыг малчид болоод бодлого боловсруулагчдад ойлгуулах нь чухал юм. Оороор хэлбэл Монголын нийгэм эдийн засгийн тогтвортой байдал бэлчээрийн эрүүл мэндээс шууд хамааралтай МАА-н үйлдвэрлэл дээр тогтдог. Тиймээс бэлчээр ашиглалтыг богино хугацааны ашиг хонжоо болон урт хугацааны тогтвортой байдлын зохистой харьцаан дээр тулгуурлах нь чухал юм.

Манай хотолбороос 2006 оноос хойш бэлчээрийн эрүүл мэндийн үнэлгээ мониторингийн арга зүйг бvс бvслvvрээр турших, нэвтрүүлэх ажлыг хийж ирсний дотор 2009-2010 оны зун бэлчээрийн эрүүл мэндийн үндэсний мониторингийн цэгүүдээс мэдээлэл цуглуулан мэдээллийн нэгдсэн баазыг бий болгох, экологийн талбарыг тодорхойлох ажлын эхлэлийг тавьлаа.